

Энэ сарын 6-7-ны одрvvдэд аймгийн Засаг дарга Х.Дармен, Хогжлийн бодлогын хэлтсийн дарга А.Болатхан, Эрчим ХХК-ний захирал Д.Мурат, Хотгор ХК-ний захирал З.Кадырхан зэрэг толооллvvд Увс аймагт ажиллав.

Манай аймгийн зvгээс Эрчим ХХК-ний уурхайн vйл ажиллагааг сэргээх, Хотгорын уурхайн нvvрс ашиглалтын талаар болон Увс аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллах, бvтээн байгуулалт, хот толовлолтийн тухай туршлага солилцох санал тавив. Дээрх асуудлаар талууд ярилцаж Эрчим ХХК-ний уурхайг мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн актаар тавигдсан зорчлийг арилгах хvртэл vйл ажиллагааг нь тvр зогсоосон богоод техник эдийн засгийн vндэслэл, байгаль орчны нарийвчилсан байдлын vнэлгээг хийлгэх, гол усны эх бvрэлдэх газарт овоолсон шороон овоолгыг зайлуулах, улсын комисс ажиллуулаагvй зэрэг зорчлийг арилгасан нохцолд тус уурхайн vйл ажиллагааг сэргээхээр болов. Харин Хотгорын уурхайд нооцод бvртгэгдсэн нvvрсийг иж бvрэн зов зохистой ашиглах талаар харилцан тохиролцоонд хvрлээ.